



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/343

Номгон

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."н", Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т заасан шаардлагыг хангаагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүргийг биелүүлээгүй XV-64000053 тусгай зөвшөөрлийн дугаар бүхий Баян-Овоо сумын нутаг Цагаан цахир хэмээх 377,34 гектар талбайн тусгай зөвшөөрөл эзэмшигч Ти Эй Ди Эй ХХК, XV-64000083 тусгай зөвшөөрлийн дугаар бүхий Өлзийт сумын нутаг Улаан дэлийн сайр хэмээх 390,3 гектар талбайн тусгай зөвшөөрөл эзэмшигч Едшин Норву ХХК, XV-64000033 тусгай зөвшөөрлийн дугаар бүхий Бөмбөгөр сумын нутаг Дайргат хэмээх 132,46 гектар талбайн тусгай зөвшөөрөл эзэмшигч Хатан трейвел ХХК-ний түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг тус тус цуцалсугай.

2.Хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн гэрчилгээг буцааж өгөхийг аж ахуйн нэгж, байгууллагын захирлуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан хуулийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

5.Энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд 30 хоногийн дотор дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэйг дурдсугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН